



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/134

Есөнбулаг сум

Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний олон улсын худалдаа, дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин бүртгэгдсэн бүс нутгаас шилжин ирэх мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хязгаарласугай.

2. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчингүй тайван бүс нутгаас чиглэсэн мал, амьтныг нэвтрүүлэхдээ эрүүл мэндийн үзлэгт хамруулж, мал эмнэлгийн цахим гэрчилгээ, лабораторийн шинжилгээний хуудсыг үндэслэн хүлээн авч, нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), сумдын Мал эмнэлэг, Мал үржлийн хяналтын улсын байцаагч нарт зөвшөөрсүгэй.

3. Мал, амьтныг бүх зориулалтаар тээвэрлэх, тууварлах хөдөлгөөнд хяналт тавьж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд аймгийн Мал эмнэлгийн газарт мэдэгдэж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар)-т үүрэг болгосугай.

4. Отор нүүдлээр өөр аймагт очсон мал сүргийн судалгааг гаргаж, оторлох гэрээний дагуу тогтоосон хугацаанд малыг буцаах арга хэмжээг нэгдсэн байдлаар зохион байгуулахыг Хүнс хөдөө аж ахуйн газар (Ж.Очир), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

